

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 5 дугаар сарын 24-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААНЫГ ДЭЭДЛЭН ХҮНДЭТГЭХ, ЗАРЛИГЛАСАН ОНОЛ СУРГААЛИАС НЬ СУРАЛЦАХ, ТҮҮНИЙ ХӨШӨӨ, ТӨРИЙН ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ ЦОГЦОЛБОРТ ТӨРИЙН ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЖ БАЙХ ТУХАЙ

Их Монгол Улсын төрийн гал голомтыг асаан бадруулж, аугаа их суу билиг, хүч чадлаар Монгол хэмээх нэрийг ертөнц дахинаа хүртээн дуурсгасан Их эзэн Чингис хааны алдар гавъяа хүн төрөлхтөнд мянга мянган жилээр бахдал бишрэлийг төрүүлж, үлгэр дууриал болох нь зүй билээ.

Эдүгээ цагт үндэсний хэмжээнд Их эзэн Чингис хааны байгуулсан түүхэн гавъяа зүтгэл, үйл хэрэг, оюунлаг билиг сургаалийг нь судлан сурталчлах, бишрэн дээдлэх, хүндэтгэн бахархах ажил багагүй хийгдэж байгааг цаашид ч хамрах хүрээ, эрч далайцыг нь нэмэгдүүлэх нь чухал юм.

Тархай бутархай олон овог, аймгийг нэгэн үзэл санаа, зорилгын дор нэгтгэн хүчирхэг Монгол Улсыг байгуулж, үл тасалдах төрт ёс, соёл, түүхийн баялаг уламжлалыг шинээр болон сэргээн хөгжүүлсэн, дэлхий дахинаа даяаршлын үзэл санааг бодитой үүтгэн хэрэгжүүлсэн мянганы суут хүн, төр, цэргийн нэн гарамгай зүтгэлтэн "Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборыг Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан монголчууд бид ёслол төгөлдөр бүтээн цогцлоосон билээ. Их эзэн Чингис хааныг дээдлэн хүндэтгэх, зарлигласан онол сургаалиас нь суралцах, түүний хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборт төрийн хэмжээнд хүндэтгэл үзүүлж байх нь зүйтэй гэж үзэн иргэд, иргэний нийгэм, улс төрийн намууд, төр захиргааны байгууллагуудаас тавьж буй саналыг харгалзан Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1.Монгол Улсын Үндэсний их баяр наадам- Ардын хувьсгалын ойн өдөр, Их Монгол Улс байгуулагдсаны ойн өдөр, Бүгд Найрамдах Улсыг тунхагласны баярын өдөр, Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр /Билгийн тооллын зуны эхэн сарын улаан тэргэл өдөр/, Монголын уламжлалт баяр-Цагаан сарын шинийн нэгний өдөр тус тус "Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборт төрийн хүндэтгэл үзүүлж байсугай.

2.Энэ өдрүүдэд орон даяар бүх байгууллага, хамт олон, сургууль, соёлын газрууд Эзэн богд Чингис хааны эш хөргийг залах, зарлиг, сургаалиас нь судлан суралцах, захиас гэрээсийг нь хэрэгжүүлэх чиглэлээр зохистой ажил өрнүүлж байх нь зүйтэй гэж үзсүгэй.

3."Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө" цогцолборт төрийн хүндэтгэл үзүүлэх журмыг боловсруулан мөрдөх болон энэхүү зарлигийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.

4.Эзэн богд Чингис хаан эцгээ дээдлэн хүндэтгэх, зарлиг сургаалиас нь суралцах, захиас гэрээсийг нь биелүүлж, сахин дагах журамт үүргээ Их Монгол Улсын гал голомтыг өвлөн залгамжилсан эдүгээгийн Монгол Улсын иргэн бүр гүнээ ухамсарлан эх орноо шинэ мянганы хөгжил дэвшил, мандал бадралын өндөрлөгт хүргэхийн төлөө эв эе эрхэмлэж, чин шударгаар хичээнгүйлэн хувь нэмрээ оруулахыг уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД